МЭДЭЭ · 2021 оны 7-р сарын 8

АЖЛЫН ХЭСГЭЭС 20 ХЭРГИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЛЭЭ



Улсын ерөнхий прокурорын тушаалаар байгуулагдсан хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэгдэж олны анхаарал татсан, мөн хуулийн байгууллагын ажилтнууд холбогдсон хэргүүдийг хянаж, шуурхай шалгаж шийдвэрлүүлэх ажлын хэсгээс 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 114 хэргийг хянаж танилцан, шуурхай шалгаж шийдвэрлүүлэх үүрэг өгч ажилласнаас 20 хэргийг шүүхэд шилжүүлж, 30 хэргийг хааж, 1 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн байна.

Мөн "иргэн Д.Янжинхорлоотой холбоотой хэргийг шийдвэрлэхдээ хувийн сонирхлоор хандсан" гэх мэдээллийн мөрөөр дээрх хэргийг дахин шалгуулж, шийдвэр гаргасан прокуроруудыг мэргэжлийн алдаа гаргасан эсэх талаар Прокурорын мэргэжлийн зөвлөлөөр дүгнэлт гаргуулж нэр бүхий прокуроруудад сахилгын шийтгэл оногдуулжээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2592